

БУЛГАН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ОРОН НУТГИЙН СОНГУУЛЬ ЗОХИОН БАЙГУУЛАХТАЙ ХОЛБОГДОН УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖҮҮЛСЭН ЗАРДЛЫН ГҮЙЦЭТГЭЛД АУДИТ ХИЙЖ, ДҮГНЭЛТ ГАРГАХ

АУДИТЫН КОД: БУА/2020/06-ГА

СОНГУУЛИЙН ЗАРДЛЫН ГҮЙЦЭТГЭЛД
ТАВИХ ДОТООД ХЯНАЛТЫГ БҮРЭН
ХЭРЭГЖҮҮЛЖ АЖИЛЛАСАН Ч ЗАРИМ
СУМДЫН СОНГУУЛИЙН ХОРООДЫН
ЗААВАР ЗӨВЛӨМЖИЙН ХЭРЭГЖИЛТ
ХАНГАЛТГҮЙ БАЙНА.

БУЛГАН АЙМАГ 2020 ОН

Булган аймаг дахь Төрийн аудитын газрын
Дарга, тэргүүлэх аудитор Д.Анхбаяр
Утас: 70342580 Цахим хаяг: Anknbayard@audit.gov.mn
Аудитын менежер Ж.Энхцоодол
Утас: 70342716 Цахим хаяг: Enkhtsoodoli@audit.gov.mn
Ахлах аудитор П.Мөнхтуяа
Утас: 70342716 Цахим хаяг: MonkhtuyaP@audit.gov.mn
Аудитор Б.Энхтөр
Утас: 70342716 Цахим хаяг: Enkhturb@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой мэдээллийг дараах хаягаар авна уу.
Цахим хуудас www.audit.mn

АГУУЛГА

Товчилсон үгийн жагсаалт.....3

Хүснэгтийн товъёг.....4

Аудитын зорилт, хамарсан хүрээ, стандарт, арга зүйн талаарх мэдэгдэл.....5

БҮЛЭГ А.Орон нутгийн сонгуульд улсын төсвөөс санхүүжүүлсэн зардлыг хууль, журмын дагуу төлөвлөж, хуваарилжээ.....6

А.1.Улсын төсвөөс санхүүжүүлсэн аймгийн ИТХ-ын 2020 оны сонгуулийн зардлыг тооцоо судалгаанд үндэслэж үр дүнтэй төлөвлөсөн байна.....6

А.1.1 Орон нутгийн сонгуулийн үйл ажиллагааг зохион байгуулах зардлыг төлөвлөхдөө СЕХ хүн ам, байршлаар нь төлөвлөж тооцоолжээ.....6

А.1.2. Аймаг, сумын ИТХ-ын сонгуулийн зардлаас тоног төхөөрөмжийн худалдан авалт хийгдээгүй байна.....6

А.1.3. Сонгуульд зарцуулагдах зардлыг 16 төрөлд багтаан төсөвлөжээ.....6

А.1.4. Улсын төсвөөс санхүүжүүлсэн зардлыг төлөвлөхдөө хууль журмыг баримтлан ажиллажээ.....7

Б. Орон нутгийн сонгууль зохион байгуулахтай холбогдсон улсын төсвөөс санхүүжүүлсэн зардлыг үр дүнтэй, арвилан хэмнэлттэй зарцуулсан ч зарим сумдын сонгуулийн хороо анхан шатны баримтын бүрдэлгүй, томилолт, буудлын хоногийг илүү тооцон олгожээ.....7

Б.1. Орон нутгийн сонгуулийн зардал, хөрөнгийн ашиглалтад дотоод хяналт хийсэн ч зарим сумдын сонгуулийн хороо нь заавар зөвлөмжийг бүрэн биелүүлж ажиллаагүй байна.....7

Б.1.1. Батлагдсан төсвийг зориулалтын дагуу нийт 398265.7 мянган төгрөгийг зарцуулж 13890.3 мянган төгрөгийн үлдэгдлийг төвлөрүүлэн ажилласан байна.....7-8

Б.1.2. Анхан шатны баримтын бүрдэлт дутуу 1841.7 мянган төгрөгийн гүйлгээ хийгдэж, томилолтын 300.0 мянган төгрөгийг илүү олгосон зөрчлүүд илэрч байна.....8

Б.1.3. Сонгуулийн зардлын гүйцэтгэлд хяналт тавьж ажилласан ч зарим сумдын зардлын гүйцэтгэлд гарсан алдаа зөрчлөөс үзэхэд дотоод хяналтаар өгсөн заавар, зөвлөмжийг хэрэгжилт хангалтгүй байна.....8

Б.1.4. Сонгуулийн байр бэлтгэх зардлаас нийт 15755.7 мянган төгрөгийг зарцуулж тайлан бүртгэлд тусгасан байна.....9

ДҮГНЭЛТ.....9

Товчилсон үгийн жагсаалт

АНСДИТХТХ	Аймаг нийслэл, сум дүүргийн ИТХ-ын тухай хууль
СЕХ	Сонгуулийн Ерөнхий хороо
НББТХ	Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал

Орон нутгийн сонгууль зохион байгуулахтай холбогдон улсын төсвөөс санхүүжүүлсэн зардлын гүйцэтгэлд аудит хийж дүгнэлт гаргах

Хүснэгтийн товъёг

№	Тайлбар	Хуудасны дугаар
Хүснэгт 1	Сонгуулийн зардлын төрөл, санхүүжилтийн дүн	6
Хүснэгт 2	Санхүүжилтийн хуваарилалт үлдэгдэл төвлөрүүлэлт	7

Аудит хийх үндэслэл, бүрэн эрх	Аудитын зорилт, хамарсан хүрээ, стандарт, арга зүйн талаарх мэдэгдэл Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 6.3.3-т заасан бүрэн эрхийн хүрээнд Төрийн аудитын газрын 2020 оны бүтээгдэхүүн ажил үйлчилгээ, төлөвлөгөөний дагуу “Орон нутгийн сонгууль зохион байгуулахтай холбогдон улсын төсвөөс санхүүжүүлсэн зардлын гүйцэтгэл”-д аудит хийлээ.
Аудитын зорилт	Улсын Их Хурлын 2020 оны ээлжит сонгууль зохион байгуулахтай холбогдсон улсын төсвөөс санхүүжүүлсэн зардлын төлөвлөлт, зарцуулалт, гүйцэтгэлд дүгнэлт гаргаж, зөвлөмж боловсруулан УИХ, Засгийн газар, холбогдох байгууллагад танилцуулж, иргэд олон нийтэд мэдээлэхэд аудитын зорилт чиглэгдсэн Аудитыг дараах дэд зорилтын хүрээнд гүйцэтгэлээ. Үүнд: - Орон нутгийн сонгуульд улсын төсвөөс санхүүжүүлсэн зардлыг хууль, журмын дагуу төлөвлөж, хуваарилсан эсэх; - Орон нутгийн сонгууль зохион байгуулахтай холбогдон улсын төсвөөс санхүүжүүлсэн зардлыг үр дүнтэй, арвилан хэмнэлттэй зарцуулсан эсэх
Аудитын хамарсан хүрээ Аудитын хязгаарлалт Аудитын арга зүй, шалгуур үзүүлэлт	Аудитад аймаг, сум, орон нутгийн сонгуулийн хороод, ЦГ, ОБГ бусад байгууллагуудыг хамрууллаа. Аудитыг гүйцэтгэхэд Гүйцэтгэлийн аудитын удирдамж (АДБОУС 3000-3100), Монгол Улсын Төрийн аудитын стандарт-Гүйцэтгэлийн аудитын журмыг ашиглах, холбогдох асуудлаар аудит хамрагдсан аймаг, сум сонгуулийн хорооны гишүүдээс ярилцлага хийх, асуулга, лавлагаа болон авах, тайлан судалгаа, баримт материалд тулган баталгаажуулалт, дүн шинжилгээ хийн аудитын судалгаа, хөтөлбөр, арга зүйн дагуу нотлох зүйл цуглуулж, холбогдох хууль журмыг үндэслэн дүгнэлт, зөвлөмж боловсрууллаа. Аудитыг Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Д.Анхбаяр хянан удирдаж, аудитын менежер Ж.Энхцоодол аудитын үе шатны чанарын хяналтыг хэрэгжүүлж, ахлах аудитор П.Мөнхтуяа, аудитор Б.Энхтөр нар хийж гүйцэтгэлээ.
Аудитын бүрэлдэхүүн, хугацаа	Аудитын удирдамжийн дагуу гүйцэтгэлийн аудитыг 2020 оны 11 дүгээр сарын 02-ны өдрөөс 2020 оны 11 дүгээр сарын 20-ны өдөр хүртэл ажлын 15 хоногт хийж аудитыг үе шатны хяналтаар хянуулж аудитын тайлан, нотлох баримтыг бэлтгэн ажиллалаа.
Хүндрэл бэрхшээл	

БҮЛЭГ А.Орон нутгийн сонгуульд улсын төсвөөс санхүүжүүлсэн зардлыг хууль, журмын дагуу төлөвлөж, хуваарилжээ.

А.1.Улсын төсвөөс санхүүжүүлсэн аймгийн ИТХ-ын 2020 оны сонгуулийн зардлыг тооцоо судалгаанд үндэслэж үр дүнтэй төлөвлөсөн байна.

А.1.1 Орон нутгийн сонгуулийн үйл ажиллагааг зохион байгуулах зардлыг СЕХ төлөвлөхдөө хүн ам, байршлаар нь төлөвлөж тооцоолжээ.

Монгол улсын СЕХ нь төсвийн тухай хуулийн 6.4, 6.5, аймгийн ИТХ-ын 2020 оны сонгуульд зарцуулагдах төсөв санхүүжилтийг хүн ам, нутаг дэвсгэрийн байршлаар нь сонгуулийн зардалд зарцуулагдах зардлыг 16 төрөлд ангилан аймгийн хэмжээнд нийт 412456.0 мянган төгрөгийг олгохоор тооцсон байна.

Үүнд: Сонгуулийн үйл ажиллагааг зохион байгуулахад шаардлагатай санал авах байрыг тохижуулах, сонгуулийн тухай хууль тогтоомж, дүрэм, журам, заавар, гарын авлага хүргэх, сургалт, сурталчилгаа, онцгой нөхцөл байдал үүссэн үед гарч болзошгүй зардал, ажиллагсдын урамшуулал, аймгийн сонгуулийн хороо болон хэсгийн хороодын бичиг хэрэг, шуудан, холбоо, унаа, албан томилолт, цалин урамшуулал, хоолны зардлуудыг улсын төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөн тусгажээ.

А.1.2. Аймаг, сумын ИТХ-ын сонгуулийн зардлаас тоног төхөөрөмжийн худалдан авалт хийгдээгүй байна.

А.1.3. Сонгуульд зарцуулагдах зардлыг 16 төрөлд багтаан төсөвлөжээ.

Аймаг сумын ИТХ-ын 2020 оны сонгуулийн зардлыг 16 төрөлд багтаан төсөвлөсөн байна. Сонгуулийн зардлын төрөл, санхүүжилтийн дүнг хүснэгтээр харуулбал:

		/төгрөгөөр/
№	Зардлын төрөл	Мөнгөн дүн
1	Тогтоол, протокол, бусад маягт хэвлүүлэх зардал	300000
2	Үнэмлэх хэвлэх зардал	2380000
3	Сонгуулийн байгууллагын ажилтан, МТБ-ийн гишүүн, даамлын сургалтын зардал	14202000
4	Аймаг, нийслэл, сум, дүүрэг, хэсгийн хорооны бичиг хэргийн зардал	9200000
5	Аймаг, нийслэл, сум, дүүрэг, хэсгийн хорооны шуудан холбооны зардал	10900000
6	Аймаг, нийслэл, сум, дүүрэг, хэсгийн хорооны унааны зардал	40700000
7	Санал авах байр, Төрийн далбаа бэлтгэх зардал	16500000
8	Саналын хуудас, санал тоолох төхөөрөмж авах, хүлээлгэн өгөх зардал	19860000
9	МТБ-ийн мэдээ дамжуулах холбоо, унааны зардал	650000
10	Эрчим хүчний эх үүсгэвэр бэлтгэх зардал	2625000
11	Сурталчилгааны зардал	8000000
12	Мэдээ дамжуулах унааны зардал	3025000
13	Томилолтын зардал	6904000
14	Болзошгүй зардал	6730000
15	Сонгуулийн байгууллагын ажилтны урамшуулал, хоолны зардал	238300000
16	Мэдээллийн технологийн багийн гишүүн, даамлын урамшуулал, хоолны зардал	31880000
Нийт дүн		412156000

А.1.4. Улсын төсвөөс санхүүжүүлсэн зардлыг төлөвлөхдөө хууль журмыг баримтлан ажиллажээ.

Булган аймаг нь аймгийн ИТХ-ын 2020 оны сонгуулийн хороонд ажиллах дарга, нарийн бичгийн дарга болон тав буюу долоон гишүүний бүрэлдэхүүнтэйгээр, мөн 16 сумын сонгуулийн хэсгийн хороонд ажиллах дарга гишүүдийг томилох тухай тогтоол гаргахдаа аймаг, нийслэл, сум дүүргийн ИТХ-ын тухай хуулийн 16.1.¹, 16.2.² гэсэн заалтуудыг баримтлан бүрэн эрхийнхээ хүрээнд мөн СЕХ-ноос ирүүлсэн төсвийн зарцуулалтын тайлбар, Сонгуулийн хороодод төсөв, хуваарилах, зарцуулах, түүнд хяналт тавих тайлан гаргах журам зэргийг баримтлан ажилласан байна.

Аймгийн ИТХ-ын 21 тойрогт 33 мандатад 83 нэр дэвшигч, сумын ИТХ-ын 75 тойрогт 340 мандатад 719 нэр дэвшигч оролцжээ.

Б. Орон нутгийн сонгууль зохион байгуулахтай холбогдсон улсын төсвөөс санхүүжүүлсэн зардлыг үр дүнтэй, арвилан хэмнэлттэй зарцуулсан ч зарим сумдын сонгуулийн хороо анхан шатны баримтын бүрдэлгүй, томилолт, буудлын хоногийг илүү тооцон олгожээ.

Б.1. Орон нутгийн сонгуулийн зардал, хөрөнгийн ашиглалтад дотоод хяналт хийсэн ч зарим сумдын сонгуулийн хороо нь заавар зөвлөмжийг бүрэн биелүүлж ажиллаагүй байна.

Б.1.1. Батлагдсан төсвийг зориулалтын дагуу нийт 398265.7 мянган төгрөгийг зарцуулж 13890.3 мянган төгрөгийн үлдэгдлийг төвлөрүүлэн ажилласан байна.

Сонгуулийн ерөнхий хорооноос аймгийн хэмжээнд 412156.0 мянган төгрөгийн санхүүжилт олгосныг аймаг болон 16 сумын ИТХ-ын сонгуулийн хороонд ажиллах дарга, гишүүд, хэсгийн хорооны тоон үзүүлэлтийн судалгаанд үндэслэн 16 төрлийн зардлаар санхүүжилтийн хуваарилалтыг хийж ажиллажээ.

Санхүүжилтийн хуваарилалт, үлдэгдэл төвлөрүүлэлтийг хүснэгтээр харуулбал:

/мян.төг/

№	Сумдын нэрс	Хуваарилсан санхүүжилт	Зарцуулалтын дүн	Үлдэгдэл
1	Баян-Агт	27197.0	27197.0	0
2	Баяннуур	12719.8	12719.8	0
3	Бугат	14951.1	14291.1	660.0
4	Булган	28759.0	28757.5	1.5
5	Бүрэгхангай	19163.8	18864.0	299.8
6	Гурванбулаг	30691.0	30595.0	96.0
7	Дашинчилэн	21830.0	21830.0	0
8	Могод	23091.0	20901.2	2189.8
9	Рашаант	19132.2	18776.6	355.6
10	Орхон	23172.4	22952.4	220.0
11	Сайхан	27079.7	26553.6	526.1
12	Сэлэнгэ	25295.7	25185.7	110.0
13	Тэшиг	26651.7	26591.7	60.0
14	Хангал	19481.1	19481.1	0
15	Хишиг-Өндөр	23300.0	22635.1	664.9
16	Хутаг-Өндөр	26259.7	26091.8	168.0
17	Булган аймаг	43380.7	34842.1	8538.6

¹ Аймаг, нийслэлийн Хурлын Тэргүүлэгчид санал авах өдрөөс 70-аас доошгүй хоногийн өмнө аймаг, нийслэлийн сонгуулийн хороог дарга, нарийн бичгийн дарга болон тав, эсхүл долоон гишүүний бүрэлдэхүүнтэй байгуулж, нийтэд мэдээлнэ.

² Аймаг, нийслэлийн сонгуулийн хороо харьяалах нутаг дэвсгэрийн хэмжээнд дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ

Нийт дүн	412156.0	398265.7	13890.3
----------	----------	----------	---------

Дээрх хүснэгтээс харахад санхүүжилтийн 97 хувь буюу 398265.7 мянган төгрөгийг зарцуулж санхүүжилтийн 3 хувийг холбогдох дансанд төвлөрүүлэн ажиллажээ.

Санхүүжилтийн үлдэгдлээс болзошгүй зардал 20, унааны зардал 17, бичиг хэрэг, шуудан холбоо, сургалтын зардлууд 6, саналын хуудас, санал тоолох төхөөрөмж авах, хүлээлгэн өгөх зардал 38 хувийг тус тус эзэлж байна.

Б.1.2. Анхан шатны баримтын бүрдэлт дутуу 1841.7 мянган төгрөгийн гүйлгээ хийгдэж, томилолтын 300.0 мянган төгрөгийг илүү олгосон зөрчлүүд илэрч байна.

Аймаг, нийслэл, сум дүүргийн ИТХ-ын 2020 оны сонгуулийн зардлын гүйцэтгэлийг сум, зардал тус бүрээр түүвэрлэн үзэхэд анхан шатны баримтын бүрдэлт дутуу, томилолтын хуудасны он сар өдрийг зөв бөглөөгүй, буудлын баримттай зөрүүтэй, хоног, буудлын мөнгийг илүү тооцож олгосон, жолоочийн тооцооны замын хуудсыг илүү дутуу хөтөлсөн зэрэг зөрчлүүд илэрч байгаа нь СЕХ-ооноос өгсөн тайлбар зөвлөмж болон НББ-ийн тухай хуулийн 13.6.³, 13.7.⁴ заалтуудыг бүрэн баримталж ажиллаагүй байна.

Үүнд: Сэлэнгэ сумын сонгуулийн хорооны мэдээлэл технологийн даамлын 6 гишүүний томилолтын хуудасны он, сар, өдөр нь буудлын баримттай зөрүүтэй, 1 хонгийн томилолт, буудлын 300.0 мянган төгрөгийг илүү олгосон зөрчилд төлбөрийн акт бичлээ.

Мөн анхан шатны баримтын бүрдэлт дутуу, нэхэмжлэх баримт болон төлбөрийн баримтын данс зөрүүтэй, төлбөрийн баримтыг давхар бичиж баримтад хавсаргасан, шатахууны цохолтоос өөр төрлийн түлш худалдан авсан зэрэг 1841.7 мянган төгрөгийн зөрчлүүд илэрч байна.

Б.1.3. Сонгуулийн зардлын гүйцэтгэлд хяналт тавьж ажилласан ч зарим сумдын зардлын гүйцэтгэлд гарсан алдаа зөрчлөөс үзэхэд дотоод хяналтаар өгсөн заавар, зөвлөмжийн хэрэгжилт хангалтгүй байна.

СЕХ-ны даргын 2020 оны 08 дугаар сарын 25-ны өдрийн А/34 тоот аймаг, нийслэлийн сонгуулийн хорооны зардлын хуваарь батлах тухай захирамж болон аймгийн ИТХ-ын тогтоол, захирамж, аймаг, нийслэл, сум, дүүргийн ИТХ-ын сонгуулийн тухай хуулийн 16.1 дэх заалтыг тус тус үндэслэн сонгуулийн хорооны дарга, нарийн бичиг, гишүүд, нягтлан бодогч, бичиг хэргийн ажилтныг томилон ажиллаж ажлын төлөвлөгөө болон гишүүдийн ажил, үүргийн хуваарийг батлан гаргаж сумдын сонгуулийн хорооны гишүүн, нягтлан бодогч нарт СЕХ-оос сонгуулийн зардлын тайлбар, зөвлөмжийн талаар НББ-ийн тухай хууль, холбогдох дүрэм журмыг баримталж ажиллуулахаар сургалт зохион байгуулж тухай бүр нь заавар зөвлөгөөг өгч арга зүйгээр ханган ажилласан байна.

Мөн сумдын сонгуулийн хорооны нягтлан бодогч нараар сонгуулийн зардлын гүйцэтгэлийн тайланг гаргуулан авч анхан шатны баримттай нь тулган баталгаажуулж архивын нэгж болгон баримтжуулан ажилласан нь сонгуулийн зардлын гүйцэтгэлд дотоод хяналтыг хэрэгжүүлэн ажилласан гэж үзэж байгаа боловч зарим сумдын зардлын гүйцэтгэлд гарсан алдаа зөрчлөөс үзэхэд өмнөх алдаа зөрчил давтагдаж байгаа нь дотоод хяналт, сургалтаар өгсөн заавар зөвлөмжийг хангалтгүй биелүүлж байгаагаар илэрхийлэгдэж байна.

³ Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна.

⁴ Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно.

Б.1.4. Сонгуулийн байр бэлтгэх зардлаас нийт 15755.7 мянган төгрөгийг зарцуулж тайлан бүртгэлд тусгасан байна.

СЕХ-оос баталсан санхүүжилтээс сонгуулийн хорооны санал авах байр, төрийн далбаа бэлтгэх зардалд 40700.0 мянган төгрөгийг баталж гүйцэтгэлээр 38905.9 мянган төгрөгийг зарцуулж үлдэгдэл 744.2 мянган төгрөгийг төвлөрүүлэн ажиллажээ.

Саналын байр бэлтгэх зардлаас үндсэн хөрөнгийн худалдан авалт хийгдээгүй, байр тохижуулахад шаардлагатай бараа материалын зардалд зарцуулж холбогдох данс бүртгэлд бүртгэн ажилласан байна.

Аудитаар нийт 2141.7 мянган төгрөгийн зөрчил илэрснээс 300.0 мянган төгрөгийн зөрчилд төлбөрийн акт, 1841.7 мянган төгрөгийн зөрчилд заавар зөвлөмж өгч ажиллалаа.

ДҮГНЭЛТ:

Аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг гаргаж байна.

- Аймгийн ИТХ-ын 2020 оны сонгуульд зарцуулагдах төсөв санхүүжилтийг хүн ам, нутаг дэвсгэрийн байршлаар нь тооцоо судалгаанд үндэслэн хууль журмын дагуу санхүүжүүлсэн байна.
- Аймгийн ИТХ-ын 21 тойрогт 33 мандатад 83 нэр дэвшигч, сумын ИТХ-ын 75 тойрогт 340 мандатад 719 нэр дэвшигч оролцжээ.
- Улсын төсвөөс санхүүжүүлсэн зардлыг үр дүнтэй, арвилан хэмнэлттэй зарцуулсан ч зарим сумдын сонгуулийн хороо анхан шатны баримтын бүрдэлт дутуу, томилолт, буудлын хоногийг 300.0 мянган төгрөгөөр илүү тооцон олгосон байна.
- Сонгуулийн байр бэлтгэх зардлаас нийт 15755.7 мянган төгрөгийг зарцуулж тайлан бүртгэлд тусгасан байна.
- Сонгуулийн зардлын гүйцэтгэлд хяналт тавьж ажилласан ч зарим сумдын зардлын гүйцэтгэлд гарсан алдаа зөрчлөөс үзэхэд дотоод хяналтаар өгсөн заавар, зөвлөмжийг хангалтгүй биелүүлж ажилласан байна.

Цаашид алдаа зөрчилгүй, холбогдох хууль, журмын дагуу анхан шатны баримтын бүрдлийг үнэн зөв бүрдүүлж ажиллах талаар заавар зөвлөгөө өгч ажиллалаа.

АУДИТЫН ТАЙЛАНГ ХЯНАСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
МЕНЕЖЕР

Д.АНХБАЯР
Ж.ЭНХЦООДОЛ

АУДИТЫН ТАЙЛАН БИЧСЭН:

АХЛАХ АУДИТОР
АУДИТОР

П.МӨНХТУЯА
Б.ЭНХТӨР

Орон нутгийн сонгууль зохион байгуулахтай холбогдон улсын төсвөөс санхүүжүүлсэн зардлын гүйцэтгэлд аудит хийж дүгнэлт гаргах
